



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/49/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2019 он	Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Дэлгэрмаа Утас: 70584207 Цахим хаяг: delgermaab@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОО	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	Error! Bookmark not defined.



		ХЭРЛЭН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Т.БОЛД ТАНАА	
ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР			
21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203			
2020.02.11 № 29			
танай	-ны №	-т	
Аудитын гэрчилгээ			
Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.			
Зөрчилгүй санал дүгнэлт Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.			
Санал дүгнэлтийн үндэслэл Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг. Аудитаар Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан. Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.			
110519510			



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Т.Болд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 04-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дэлгэрмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймгийн Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.



Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэх”-д оршино.

Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутгийн иргэдийн нутгийн өөрөө удирдах байгууллагын мэдээллийг нэмэгдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Байхгүй

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Axplorer” программ хангамж ашигладаг байна.

Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБООУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардал-г сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 173749,6 мянган төгрөгөөс тооцон 3475,0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 9805,3 мянган төгрөгөөр тооцсон нь материаллаг байдлын суурийг нийт орлогоос тооцоход санхүүжилтээс бүрддэг, нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн өөрчлөлт хийгдээгүй тул нийт зардлыг сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5967,3 мянган төгрөгөөр буюу 36,7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	4488,2	4236,1	252.1
Үндсэн хөрөнгө	25362,3	25362,3	0,0
Нийт хөрөнгө	16243,8	10276,5	5967,3
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	16243,8	10276,5	5967,3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	16243,8	10276,5	5967,3

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь өмнөх онд үлдэгдэлтэй байсан нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгөнд гүйлгээ гараагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10276,5 мянган төгрөг болж 5967,3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдлаас шалтгаалжээ.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орлого бүрдүүлдэг байгууллага биш тул орлогын төлөвлөгөө тусгагдаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаанд зориулан 242301,6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 241942,0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 359,6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 241942,0 мянган төгрөг буюу 99,8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.



Нэмэлт төсөв: Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 1000,0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 241000,0 мянга, нийт 242000,0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Үүнээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 1000,0 мянган төгрөг, хэлмэгдлийн нөхөн олговорт 241000,0 мянган төгрөг, нийт 242000,0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 10 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 14455,7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 8455,7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 6000,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 14455,7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 8455,7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Нийт худалдан авалтын 49.9 хувь буюу 8.4 сая төгрөг нь татварын нэгдсэн цахим хуудас дахь Е-баримтад бүртгэгдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу тайлант оны эцэст тооллогын тушаал гаргаагүй, тооллогын бүртгэлийг бүрэн хийгээгүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-тай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

Аудитаар илэрсэн 6000,0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 7 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн байна.



2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын **агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс** урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт: Шатахууны зарцуулалтын анхан шатны баримтыг шалгахад жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтөлдөггүй, ирсэн явсан цаг хугацаа байхгүй, албан ажлаар хаана, ямар ажил гүйцэтгэсэн нь тодорхойгүй байна. Мөн тооцооны хуудсанд автомашин хэрэглэсэн ажилтны тэмдэглэгээнд ИТХ-ын дарга гарын үсэг зурсан байгаа нь ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх албан тушаалтны жагсаалтад хамаарахгүй байна.

1.2. Эрсдэл: Хууль, тогтоомж хэрэгжихгүй байх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 4 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Данс-ны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4488240,00	4236090,00
35	БАРАА МАТЕРИАЛ	4488240,00	4236090,00
354	Хангамжийн материал	4488240,00	4236090,00
35410	Бичиг хэргийн материал	2997590,00	2847090,00
35420	Аж ахуйн материал	1490650,00	1389000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11755595,48	6040405,47
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0,00	0,00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11755595,48	6040405,47
392	Биет хөрөнгө	11675595,45	6000405,43
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9600000,00	9600000,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3794891,99	-5515292,17
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15562269,00	15562269,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9691781,56	-13646571,40
393	Биет бус хөрөнгө	80000,03	40000,04
39301	Програм хангамж	200000,00	200000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-119999,97	-159999,96
39303	Бусад биет бус хөрөнгө		
39304	Хуримтлагдсан элэгдэл		
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0,00	0,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	16243835,48	10276495,47
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0,00	0,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16243835,48	10276495,47
51	Засгийн газрын хувь оролцоо	16243835,48	10276495,47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5170000,00	5170000,00
51101	Өмч: - төрийн	5170000,00	5170000,00
512	Хуримтлагдсан үр дүн	11073835,48	5106495,47
51210	Өмнөх үеийн үр дүн	11073835,48	11073835,48
51220	Тайлант үеийн үр дүн	0,00	-5967340,01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	16243835,48	10276495,47



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	171475100,00	484301600,00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	150000,00	0,00
110	Орлогын албан татвар	150000,00	0,00
1100	Хувь хүний орлогын албан татвар	150000,00	0,00
110003	Хөрөнгийн орлого	150000,00	0,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	171325100,00	484301600,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2000000,00	242000000,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0,00	1000000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2000000,00	241000000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	169325100,00	242301600,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	169325100,00	242301600,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	173749640,44	490268940,01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	173749640,44	490268940,01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	140829272,03	422024647,83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	85110700,00	98947249,82
210101	Үндсэн цалин	66607516,00	77163649,82
210104	Урамшуулал	18503184,00	21783600,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7945816,49	9610000,00
210201	Тэтгэврийн даатгал	5287416,49	6512000,00
210202	Тэтгэмжийн даатгал	638900,00	619800,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	557600,00	774500,00
210204	Ажилгүйдлийн даатгал	132700,00	154700,00
210205	Эрүүл мэндийн даатгал	1329200,00	1549000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	9996859,10	8665221,00
210401	Бичиг хэрэг	2297750,00	1880200,00
210402	Тээвэр, шатахуун	7200000,00	6000000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	499109,10	476571,00
210404	Ном, хэвлэл	0,00	186000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0,00	122450,00
2105	Нормативт зардал	100000,00	0,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100000,00	0,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2062300,00	2173800,00
210604	Урсгал засвар	2062300,00	2173800,00
2107	Томилолт, зочны зардал	1323500,00	578000,00
210702	Дотоод албан томилолт	1323500,00	578000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1300000,00	240219565,00



210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1300000,00	240219565,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32990096,44	61830812,01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28492516,00	56115622,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4497580,44	5715190,01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32920368,41	68244292,18
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	31000000,00	31000000,00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	31000000,00	31000000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1680000,00	36884700,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0,00	14591545,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1680000,00	22293155,00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	240368,41	359592,18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	240368,41	359592,18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-2274540,44	-5967340,01
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	831887,68	0,00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	831887,68	0,00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-831887,68	0,00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-3106428,12	-5967340,01

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	171325100,00	484301600,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	171325100,00	484301600,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2000000,00	242000000,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0,00	1000000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2000000,00	241000000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	169325100,00	242301600,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	169325100,00	242301600,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	171325100,00	484301600,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	171325100,00	484301600,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	138404731,59	416057307,82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	85110700,00	98947249,82
210101	Үндсэн цалин	66453000,00	77163649,82
210104	Урамшуулал	18657700,00	21783600,00



2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7945816,49	9610000,00
210201	Тэтгэврийн даатгал	5287416,49	6512000,00
210202	Тэтгэмжийн даатгал	638900,00	619800,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	557600,00	774500,00
210204	Ажилгүйдлийн даатгал	132700,00	154700,00
210205	Эрүүл мэндийн даатгал	1329200,00	1549000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	10133249,10	8392271,00
210401	Бичиг хэрэг	1934140,00	1530700,00
210402	Тээвэр, шатахуун	7200000,00	6000000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	499109,10	476571,00
210404	Ном, хэвлэл	500000,00	385000,00
2105	Нормативт зардал	442250,00	0,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	442250,00	0,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3656700,00	2194600,00
210602	Тавилга	1660000,00	0,00
210604	Урсгал засвар	1996700,00	2194600,00
2107	Томилолт, зочны зардал	1323500,00	578000,00
210702	Дотоод албан томилолт	1323500,00	578000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1300000,00	240219565,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1300000,00	240219565,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28492516,00	56115622,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28492516,00	56115622,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32920368,41	68244292,18
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	31000000,00	31000000,00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	31000000,00	31000000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1680000,00	36884700,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0,00	14591545,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1680000,00	22293155,00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	240368,41	359592,18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	240368,41	359592,18
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0,00	0,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0,00	0,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5 170 000,00	0,00	11 073 835,48	16 243 835,48
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5 170 000,00	0,00	11 073 835,48	16 243 835,48
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0,00
C07	Тайлант үеийн үр дүн				0,00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5 170 000,00	0,00	11 073 835,48	16 243 835,48
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5 170 000,00	0,00	11 073 835,48	16 243 835,48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0,00	0,00	0,00	0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5 170 000,00	0,00	11 073 835,48	16 243 835,48
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0,00	0,00	0,00	0,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0,00	0,00	0,00	0,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0,00	0,00	0,00	0,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0,00	0,00	0,00	0,00
D08	Тайлант үеийн үр дүн	0,00	0,00	-5 967 340,01	-5 967 340,01
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5 170 000,00	0,00	5 106 495,47	10 276 495,47

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	242301600,00	241942007,82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	242301600,00	241942007,82



210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	174416900,00	174057307,82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	99225100,00	98947249,82
210101	Үндсэн цалин	77441500,00	77163649,82
210104	Урамшуулал	21783600,00	21783600,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9680900,00	9610000,00
210201	Тэтгэврийн даатгал	6582900,00	6512000,00
210202	Тэтгэмжийн даатгал	619800,00	619800,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	774500,00	774500,00
210204	Ажилгүйдлийн даатгал	154700,00	154700,00
210205	Эрүүл мэндийн даатгал	1549000,00	1549000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	8400100,00	8392271,00
210401	Бичиг хэрэг	1500600,00	1530700,00
210402	Тээвэр, шатахуун	6000000,00	6000000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	514500,00	476571,00
210404	Ном, хэвлэл	385000,00	385000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2194700,00	2194600,00
2107	Томилолт, зочны зардал	578000,00	578000,00
210702	Дотоод албан томилолт	578000,00	578000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	220300,00	219565,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	220300,00	219565,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54117800,00	54115622,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54117800,00	54115622,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67884700,00	67884700,00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	31000000,00	31000000,00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	31000000,00	31000000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36884700,00	36884700,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14591500,00	14591545,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22293200,00	22293155,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	242301600,00	241942007,82
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	242301600,00	241942007,82
131001	Улсын төсвөөс санхүүжих	242301600,0	241942007,82
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0,0	0,0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)		
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)		
650003	Ажлын албаны албан хаагч (АА)		
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)		
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)		
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)		
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)		



Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

650010	Гэрээт ажилтан		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)		